

**“Дорнод худалдаа” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн
хурлын тэмдэглэл**

2018.04.25

Чойбалсан хот

Дорнод худалдаа ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурал “Дорнод худалдаа” ХК-ны 204 тоот хурлын өрөөнд 2018 оны 04-р сарын 25-ны өдрийн Лхагва гарагийн 10:00 цагт эхлэв.

Хурлын дарга Д.Шинэбаяр, Тооллогын комиссын дарга Л.Цэдэн гишүүдээр Ц.Содбаяр, Ц.Шинэзориг нар ажиллав.

Тооллогын комиссын дарга Л.Цэдэн хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл танилцуулав. Хуралд оролцож буй 67661 ширхэг хувьцаа нь 73969 ширхэг хувьцааны 91,5 хувийг бүрдүүлж байгаа тул хурал хуралдах ирц бүрдсэн болохыг мэдээлэв.

Д.Шинэбаяр: Өнөөдрийн амар амгаланг айлтгая. Ингээд ээлжит хурлын ирц бүрдсэний дагуу хурлыг эхлээ. Хурлыг даргалж байгаагын хувьд эхлээд хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг батлах нь зүйтэй. Хурлын дэгийг танилцуулья.

1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/	10:00-10:15
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	30 минут
5	Асуулт, хариулт, санал дүгнэлт тавих	30 минут
6	Санал хураалт	20 минут
7	Хурлын засварлага	15 минут
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10	Хурлыг хаах /хурлын дарга/	5 минут

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналтай батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.
Хэлэлцэх асуудал:

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
- Ноогдол ашиг хувиарлахгүй байх талаар гарсан шийдвэрийг танилцуулах
- Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах

- Компанийн шинээр барьж буй худалдааны төвийн барилга барихаар авсан хөрөнгө оруулалтын зээлийг богино хугацаанд барагдуулах талаар

- Компанийн томоохон үл хөдлөх хөрөнгө болох СМУ-д байрлалтай АФТА ХХК-ийн түрээслэж буй 200мкв талбай бүхий барилгыг худалдах тухай

Уг асуултуудаас гадна хэлэлцэх асуудал байвал саналаа хэлнэ үү.

Тооллогын комиссын дарга Л.Цэдэн: Тооллогын комиссын анх дугаар тогтоолыг танилцуулав. Тооллогын комисс хэлэлцэх асуудалд илээр санал хураахад 100% саналтай байна.

Д.Шинэбаяр: Ингээд батлагдсан асуудлууд дарааллын дагуу явагдана. Нэгдүгээр асуудал болох 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Ц.Шинэбадам танилцуулав. Санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг Аудитын хорооны гишүүн Ц.Содбаяр танилцуулав.

Гишүүн Шинэзориг: Шинээр барьж буй барилга зураг төсөвийн дагуу баригдаж чадаж байна уу. Компанийн авлага нилээн барагдуулсан байна. Хөрөнгө оруулалтын зээлийг төлж барагдуулах талаар ямар санал бодолтой байгааг гишүүдээс асууя.

Компанийн гүйцэтгэх захирал Д.Шинэбаяр: Шинээр барьж буй 3 давхар худалдааны төвийн барилгын явц тайлангийн талаар танилцуулав. Барилга одоогийн байдлаар 1,4 тэрбум төгрөг зарцуулж барилгын явц 80 хувьтай зураг төсөвийн дагуу явагдаж байна. Бид төсөвөө хэмнэх үүднээс материалын зардлыг өөрсдөө явж судалж авсанаар төсөвөө нилээд хэмнэж ажиллаж байгаа. 2018 оны 2 дахь улиралд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Тооллогын комиссын дарга Л.Цэдэн: Гишүүдийн саналыг илээр хурааж Тооллогын комиссын 01 тоот тогтоолыг танилцуулав.

Шинэбадам: Компанийн 2017 оны ноогдол ашгийг шинээр барьж буй хөрөнгө оруулалтад зарцуулах тул тараахгүй байхаар ТУЗ шийдвэрлэсэнийг танилцуулав.

Д.Тунгалагтуул: Компани урт хугацааны их хэмжээний зээлтэй тул бид ногдол ашиг тараахгүй байх асуудлыг хүлээн зөвшөөрч байна.

Насрайжав: Компани эхний ээлжинд өр төлбөрөөс гарах хэрэгтэй. Иймд ногдол ашиг тараахгүй шийдвэрийг дэмжиж байна.

Тооллогын комиссын дарга Цэдэн: Гишүүдийн саналыг илээр хурааж Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг танилцуулав.

Шинэбадам: Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.

Билгүүн: 2018 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт үүрэг болгож байна.

Д.Шинэбаяр. Бизнес төлөвлөгөөний талаар ярилцах асуудал байхгүй бол саналаа хураагаад дараагын асуудалдаа орох уу.

Тооллогын комиссын дарга Л.Цэдэн: Гишүүдийн саналыг илээр хураан Тооллогын комиссийн 03 тоот тогтоолыг танилцуулав.

Гүйцэтгэх захирал Д.Шинэбаяр: Компани хөрөнгө оруулалтын зориулалтаар авсан банкны зээлийн үлдэгдэл 500 сая төгрөгийг ойрын хугацаанд төлж барагдуулах саналтай байна. Иймд АФТА ХХК компанид түрээслэж буй 200мкв талбай бүхий улаан дэлгүүрийн барилгыг худалдах саналтай байна. Та бүхний саналыг сонсоё.

Д.Тунгалагтуул: Санал нэгтэй байна. Иймд уг барилгыг зах зээлийн үнэлгээг хийлгэн худалдахыг миний хувьд татгалзах зүйлгүй.

Билгүүн: Санал нэгтэй байна. Үл хөдлөх хөрөнгө борлуулах ажлын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгах саналтай байна.

Д.Шинэбаяр: Өөр гишүүдээс хэлэх санал байхгүй бол саналаа хураацгаая.

Тооллогын комиссын дарга Л.Цэдэн: Банкны зээлийг барагдуулах асуудал дээр гишүүдийн саналыг илээр хураан Тооллогын комиссын 04 тоот тогтоолыг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Л.Цэдэн: Компанийн үл хөдлөх хөрөнгө болох улаан дэлгүүрийн барилга худалдах асуудал дээр гишүүдээс илээр санал хураан Тооллогын комиссын 05 тоот тогтоолыг танилцуулав.

Шийдвэрлэсэн нь:

Д.Шинэбаяр хурлаас гарах тогтоолын төслөө танилцуулна уу.

1-р тогтоолын төслийн танилцуулав. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийн тухай Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав.

2-р тогтоолын төслийг танилцуулав. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав

3-р тогтоолын төслийн танилцуулав. Компанийн банкнаас авсан урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийг төлж барагдуулах тухай Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав

4-р тогтоолын төслийн танилцуулав. Компанийн зээлийг төлөхийн тулд үл хөдлөх хөрөнгө болох улаан дэлгүүрийн барилгыг худалдах тухай Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав

Д.Шинэбаяр: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 5 асуудлыг хэлэлцэж 5 тогтоол гаргалаа. Хурал 15 цаг 10 минут хааж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж дууслаа. Хуралд оролцогчид амжилт хүслээ.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Хурал зохион байгуулах комиссын

нарийн бичгийн дарга  Н.Хонгорзул

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Хурлын дарга Д.Шинэбаяр